

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ФОРВАРД ГЭРЭЭ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг үндэслэн нэг талаас _____-ийг төлөөлж _____/цаашид “Худалдагч” гэх/, нөгөө талаас _____-ийг төлөөлж _____/цаашид “Худалдан авагч”, хамтад нь “Талууд” гэх/ болон “Хөдөө аж ахуйн бирж” ХХК /цаашид “Бирж” гэх/ нар доорхи нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.
- 1.2. Гэрээний зорилго нь худалдагч болон худалдан авагч талууд гэрээнд заасан нөхцөлийн дагуу бараа, түүхий эд худалдах, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.3. Талууд биржийн арилжаанд брокерын компани, хоршоогоор дамжуулан оролцож, худалдах, худалдан авах бараа, түүхий эдийн төрөл, жин болон нийлүүлэх хугацааг тогтооно.
- 1.4. Худалдагч тал гэрээнд заасан бараа, түүхий эдийг нийлүүлэх журмын дагуу бараа, түүхий эдийг худалдан авагч талд нийлүүлэх, худалдан авагч нь бараа, түүхий эдийг зохих ёсоор хүлээн авч, төлбөрийг төлнө. Энэ асуудлыг Биржийн “Клиринг, төлбөр тооцооны журам” болон энэхүү гэрээгээр зохицуулна.
- 1.5. Дараах баримт бичгүүд нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.
 - 1.5.1. Хөдөө аж ахуйн биржийн гэрээний стандарт (цаашид “Биржийн гэрээний стандарт” гэнэ);
 - 1.5.2. Хөдөө аж ахуйн биржээр арилжих бараа, түүхий эдийн тодорхойлолт (цаашид “Барааны тодорхойлолт” гэнэ);
 - 1.5.3. Хөдөө аж ахуйн биржийн Клиринг, төлбөр тооцооны журам (цаашид “Төлбөр тооцооны журам” гэнэ);
 - 1.5.4. Гэрээнд харгалзах захиалгын мэдээлэл, тэдгээрийн тулгалт хийгдсэн хэлцэл;
 - 1.5.5. Биржийн арилжаатай холбоотой бирж болон төрийн эрх бүхий байгууллагаас баталсан бусад дүрэм, журмууд;
 - 1.5.6. Талуудын бусдад олгосон итгэмжлэл.
- 1.6. Нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.6.1. **“Арилжаанд оролцогч”** гэж биржтэй гишүүнчлэлийн гэрээ бүхий брокерын компани, хоршоо болон тэдгээртэй зуучлалын гэрээ бүхий харилцагчийг хамтад нь ойлгоно.
 - 1.6.2. **“Банк”** гэж биржтэй хамтран ажиллах гэрээ бүхий арилжааны банкийг;
 - 1.6.3. **“Бирж”** гэж Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийг;
 - 1.6.4. **“Талууд”** гэж зөвхөн бараа худалдах, худалдан авахаар тохиролцсон худалдагч болон худалдан авагч талыг;
 - 1.6.5. **“Гэрээ хаагдах өдөр”** гэж гэрээний хавсралт 1-т заасан бараа, түүхий эд хүлээлцэх сүүлийн өдрийг;

- 1.6.6. **“Бараа, түүхий эд”** гэж талуудын өгсөн захиалгын үндсэн дээр гэрээний хавсралт 1-т тодорхойлсон нийлүүлбэл зохих нийт бараа, түүхий эдийг;
- 1.6.7. **“Зуучлалын гэрээ”** гэж брокерын компани, хоршоо болон түүний харилцагчийн хооронд байгуулсан данс нээх, арилжаанд зуучлах тухай харилцааг зохицуулсан гэрээг;
- 1.6.8. **“Хүлээлцэх акт”** гэж худалдагч бараа, түүхий эдийг худалдан авагчид нийлүүлснийг нотлох баримт бичгийг.

Хоёр. Бараа, түүхий эд

2.1 Худалдагч нь худалдан авагчид Барааны тодорхойлолтын хоёрдугаар бүлэгт заасан техникийн шаардлагад нийцсэн бараа, түүхий эдийг худалдана.

Гурав. Төлбөр тооцоо

- 3.1 Гэрээгээр нийлүүлэх бараа, түүхий эдийн үнийг Биржийн “Клиринг, төлбөр тооцооны журам”-д заасны дагуу тооцно.
- 3.2 Гэрээ хаагдахаас өмнө талуудын хүргэлтийн болон төлбөр тооцооны дэнчинг холбогдох дансанд байршуулах, гэрээ хаагдаж хүлээлцэх акт үйлдсэний дараа бараа, түүхий эдийн төлбөрийг худалдан авагчаас нэхэмжлэх, худалдагчид шилжүүлэхтэй холбоотой харилцааг Биржийн “Клиринг, төлбөр тооцооны журам”-аар зохицуулна.

Дөрөв. Бараа, түүхий эд хүлээлцэх журам

- 4.1 Талууд бараа, түүхий эдийг гэрээний хавсралт 1-т заасан газар, хугацаанд хүлээлцэх ба уг хугацааг хэтрүүлэхийг хориглоно.
- 4.2 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хавсралт 1-т заасан хугацаанаас өмнө бараа, түүхий эдийг хүлээлцэж болно. Энэ тохиолдолд хугацаанаас өмнө бараа, түүхий эд хүлээлцэх тухай мэдэгдлийг биржид хүргүүлнэ.
- 4.3 Гэрээний хавсралт 1-т заасан бараа, түүхий эд хүлээлцэх газрыг талууд өөрчлөхөд гэрээний 5.2-т заасан журам адил үйлчилнэ.
- 4.4 Гэрээ хаагдахаас өмнөх ажлын 3 өдрийн дотор талууд бараа, түүхий эд хүлээлцэх хугацаа, газрыг өөрчлөхийг хориглоно.
- 4.5 Худалдагч гэрээний хавсралт 1-т заасан газар, хугацаанд бараа, түүхий эдийг өөрийн зардлаар тээвэрлэж, нийлүүлнэ.
- 4.6 Бараа, түүхий эд хүлээлцэхэд дараах этгээд, эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч байлцана. Үүнд:
- 4.6.1 Худалдагч тал
 - 4.6.2 Худалдагч талын брокер, хоршоо
 - 4.6.3 Худалдан авагч тал,
 - 4.6.4 Худалдан авагч талын брокер, хоршоо

4.7 Бараа, түүхий эдийг хүлээлцэхэд худалдагч тал дараах баримт бичгийг бүрдүүлнэ.
Үүнд:

4.7.1 Бараа, түүхий эдийн гарал үүслийн бичиг,

4.7.2 Лабораторийн дүгнэлт гаргуулсан бол түүнийг хавсаргах

4.8 Бараа, түүхий эд хүлээлцэх үед бараа, түүхий эдийн ангилал, чанарын талаар талуудын хооронд үүссэн маргааныг хөндлөнгийн лабораторийн дүгнэлтээр шийдвэрлэнэ.

4.9 Бараа, түүхий эдийг Стандартчилал, хэмжил зүйн газрын баталгаажуулсан жингээр жинлэн хүлээлцэнэ. Жин, түүний бүрэн бүтэн байдлыг худалдан авагч тал хариуцна.

4.10 Гэрээнд заасан болон нийлүүлсэн бараа, түүхий эдийн жингийн зөрүүний асуудлыг дараах байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:

4.10.1 Жинлэсэн бараа, түүхий эдийн нийт хэмжээ Биржийн гэрээний стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнд хэлбэлзэж байвал худалдан авагч бараа, түүхий эдийг бүхэлд нь хүлээн авах үүрэг хүлээнэ.

4.10.2 Жинлэсэн бараа, түүхий эдийн нийт хэмжээ Биржийн гэрээний стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү гарсан тохиолдолд хэтэрсэн жинд ногдох бараа, түүхий эдийг худалдан авагч хүлээн авахаас татгалзах эрхтэй.

4.10.3 Жинлэсэн бараа, түүхий эдийн нийт хэмжээ Биржийн гэрээний стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс дутсан тохиолдолд худалдан авагч тухайн бараа, түүхий эдийг бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.

4.11 Бараа, түүхий эдийг хүлээлцсэн баримтыг үйлдэнэ. Хүлээлцсэн баримт үйлдэхэд дараах шаардлагыг тавина. Үүнд:

4.11.1 Гэрээний 6.3-д заасан этгээдүүд гарын үсэг зурах, тамга тэмдгээр баталгаажуулах

4.11.2 Лабораторийн дүгнэлт гаргуулсан бол түүнийг хавсаргах

4.12 Талууд бараа хүлээлцсэн баримт үйлдсэнээр хүлээлцэх ажиллагааг дууссанд тооцно.

4.13 Худалдагч талын брокер бараа хүлээлцсэн баримтыг ажлын 1 өдрийн дотор биржид хүргэх үүрэг хүлээнэ.

4.14 Бараа, түүхий эд хүлээлцэхтэй холбоотой зардлыг талууд дараах байдлаар хариуцна. Үүнд:

4.14.1 Хүлээлцэх актад гарын үсэг зурах хүртэл худалдагч тал,

4.14.2 Хүлээлцэх акт зурснаас хойш худалдан авагч тал.

Тав. Талуудын эрх, үүрэг

5.1 Худалдагч тал хууль тогтоомжид зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

5.1.1 Бараа, түүхий эдийг гэрээнд заасан газар, хугацаанд гэрээнд заасан нөхцөлөөр Худалдан авагчид нийлүүлэх;

5.1.2 Монгол Улсын холбогдох стандарт болон Барааны тодорхойлолтод нийцсэн бараа, түүхий эдийг худалдан авагчид нийлүүлэх;

5.1.3 Хүлээлцэх акт үйлдэх хүртэлх холбогдох зардал, эрсдэлийг хариуцах;

5.1.4 Биржийн арилжаа, төлбөр тооцоотой холбоотой биржээс тогтоосон шимтгэл, хураамжийг төлөх;

- 5.1.5 Бараа, түүхий эдийг нийлүүлэхтэй холбоотой бичиг баримтыг худалдан авагчид гаргаж өгөх;
 - 5.1.6 Бараа, түүхий эд нийлүүлсний төлбөрийг тохирсон хугацаанд авах, хугацаа хэтэрсэн тохиолдолд шаардах.
- 5.2 Худалдан авагч хууль тогтоомжид зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 5.2.1 Бараа, түүхий эдийг гэрээнд заасан газар, хугацаа, нөхцлөөр хүлээн авах;
 - 5.2.2 Биржийн “Төлбөр тооцооны журам”-д заасан нөхцөл болон биржээр бараа, түүхий эд худалдах, худалдан авах форвард гэрээгээр тохиролцсон нөхцлийн дагуу бараа, түүхий эдийн төлбөрийг төлөх;
 - 5.2.3 Биржийн арилжаа, төлбөр тооцоотой холбоотой Биржээс тогтоосон шимтгэл, хураамжийг төлөх;
 - 5.2.4 Бараа, түүхий эдийг хүлээлцэх акт үйлдсэний дараа үүсэж болох аливаа эрсдэлийг хариуцах;
 - 5.2.5 Биржийн барааны тодорхойлолт, гэрээний нөхцөл, стандартад нийцсэн бараа, түүхий эдийг хүлээн авах.

Зургаа. Хориглох зүйлс

- 6.1 Талуудад дараах зүйлийг хориглоно. Үүнд:
- 6.1.1 Худалдагч бараа, түүхий эдийг нийлүүлэхээс татгалзах, хугацаандаа нийлүүлэхгүй байх,
 - 6.1.2 Худалдан авагч бараа, түүхий эдийг худалдан авахаас татгалзах, бараа, түүхий эдийг зохих ёсоор хүлээж авахгүй байх,
 - 6.1.3 Худалдан авагч бараа, түүхий эдийг нийлүүлэхэд өөрөө буюу өөрийн төлөөлөгчийг ирүүлэхгүй байх,
 - 6.1.4 Худалдан авагч гэрээний төлбөрийг гэрээнд заасан нөхцөл, холбогдох журмын дагуу төлөхгүй байх.
- 6.2 Гэрээний 6.1-т тодорхой зүйлсийг хориглохоор заасан нь тус зүйлд заагаагүй гэрээг зөрчихөд чиглэсэн бусад үйлдлийг хийхийг зөвшөөрсөн утгыг илэрхийлэхгүй болно.
- 6.3 Гэрээний 6.1 заалтыг зөрчсөн тал гэрээний 7 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

Долоо. Гэрээний зөрчил ба хариуцлага

- 7.1 Талууд биржээс баталсан дүрэм, журмууд болон гэрээний аль нэг заалтыг зөрчсөн тохиолдлыг гэрээний зөрчил гэж үзнэ.
- 7.2 Аль нэг тал гэрээний зөрчил гаргасны улмаас нөгөө талд, эсхүл гуравдагч этгээдэд хохирол учруулсан бол тухайн хохирлыг зөрчил гаргасан тал арилгах үүрэгтэй.
- 7.3 Худалдагч тал гэрээний зөрчил гаргасан тохиолдолд гэрээний 7.2-т зааснаар хохирлыг арилгасан эсэхээс үл хамааран дараах хариуцлагыг хүлээнэ. Үүнд:
- 7.3.1 Бараа, түүхий эдийг хугацаандаа нийлүүлээгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алдангийг төлөх.
 - 7.3.2 Худалдагч талын брокерын биржийн арилжаанд оролцох эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасуулах саналыг биржид хүргүүлэх,
 - 7.3.3 Худалдагчийн брокерын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх,
 - 7.3.4 Биржээс баталсан холбогдох журамд заасан бусад хариуцлага.
- 7.4 Худалдан авагч нь гэрээний зөрчил гаргасан тохиолдолд гэрээний 7.2-т зааснаар хохирлыг арилгасан эсэхээс үл хамааран дараах хариуцлагыг хүлээнэ.

- 7.4.1 Төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алдангийг төлөх.
 - 7.4.2 Худалдан авагч талын брокерын биржийн арилжаанд оролцох эрхийг 3 жил хүртэл хугацаагаар хасах саналыг биржид хүргүүлэх,
 - 7.4.3 Худалдан авагчийн брокерын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх,
 - 7.4.4 Худалдан авагчийн гаргасан зөрчлийн талаар биржийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх,
 - 7.4.5 Биржээс баталсан холбогдох журамд заасан бусад хариуцлага.
- 7.5 Гэрээний зөрчил гаргасан тал зөрчлийн улмаас үүссэн хохирлыг үл маргах журмаар барагдуулсан нь түүнийг гэрээний 7.3, 7.4-т заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 7.6 Худалдагч нь бараа, түүхий эдийг гэрээнд заасан газар, хугацаанд гэрээнд заасан нөхцөлөөр Худалдан авагчид нийлүүлээгүй буюу гэрээг зөрчсөн тохиолдолд түүнээс үүсэх хохирлыг хариуцаж гэрээнд заасан хариуцлагыг хүлээнэ.
- 7.7 Худалдан авагч нь бараа, түүхий эдийг хугацаандаа хүлээж аваагүй буюу гэрээг зөрчсөн тохиолдолд түүнээс үүсэх хохирлыг хариуцаж гэрээнд заасан хариуцлагыг хүлээнэ.

Найм. Гэрээг цуцлах

- 8.1 Талууд дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно.
- 8.1.1 Нөгөө тал гэрээний 8.1-т заасан хориглох зүйлсийг зөрчсөн,
 - 8.1.2 Аль нэг тал, эсвэл түүний брокерын биржтэй холбоотой үйл ажиллагаа явуулах эрхийг эрх бүхий байгууллага хүчингүй болгосон,
 - 8.1.3 Гэрээний 11.5-д заасан үндэслэлээр худалдагч тал бараа, түүхий эдийг нийлүүлэх боломжгүй болсон,
- 8.2 Талууд гэрээний 8.1-т зааснаас бусад үндэслэлээр харилцан тохиролцож гэрээг цуцалж болно. Талууд харилцан тохиролцож гэрээг цуцалсан тохиолдолд ажлын 1 өдрийн дотор Биржид мэдэгдэнэ.
- 8.3 Аль нэг тал гэрээний 8.1-т заасан үндэслэлээр гэрээг цуцлах шаардлагатай үзвэл нөгөө талдаа болон гэрээний 10.2-т заасан арбитрт нэн даруй мэдэгдэж, гэрээ цуцлах саналыг гаргана.
- 8.4 Арбитр гэрээний 8.3-т заасан саналыг хүлээн авч гэрээг цуцлах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 8.5 Гэрээний 8.1.1, 8.1.2-т заасан үндэслэлээр гэрээ цуцлагдсан тохиолдолд буруутай тал Гэрээний 7 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.
- 8.6 Гэрээг энэ зүйлд зааснаас бусад үндэслэл, журмаар цуцлахыг хориглоно.

Ес. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

- 9.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас аль нэг тал гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол түүнийг гэрээг зөрчсөн гэж үзэхгүй.
- 9.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсэд дараах нөхцөлүүд хамаарна. Үүнд:
- 9.2.1 Газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт зэрэг Талуудын хүсэл зоригоос үл хамааран үүсч болох байгалийн хүчин зүйл,
 - 9.2.2 Хуульд нийцсэн төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр,
 - 9.2.3 Нийтийг хамарсан ажил хаялт, үймээн самуун, халдлага, эсэргүүцлийн хөдөлгөөн.

- 9.3 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон гэж үзсэн тал энэ тухайгаа нөгөө талдаа болон гэрээний 12.2-т заасан арбитрт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.
- 9.4 Тухайн нөхцөл байдал нь гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл мөн эсэхийг холбогдох баримтад тулгуурлан арбитр шийдвэрлэнэ.
- 9.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл аль ч тал гэрээг цуцлах эрхтэй.

Арав. Маргаан шийдвэрлэх

- 10.1 Талуудын хооронд үүссэн маргааныг талууд өөрсдөө болон брокер, хоршоогоор дамжуулан зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг хичээх үүрэгтэй.
- 10.2 Талууд маргааныг гэрээний 10.1-д заасан аргаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд холбогдох хууль шүүхийн байгууллагад хандаж эцэслэн шийдвэрлүүлнэ.

Арван нэг. Бусад

- 11.1 Гэрээг монгол хэл дээр, бичгээр гурван хувь үйлдсэн бөгөөд талууд тус бүр нэг нэг хувийг хадгална.
- 11.2 Гэрээ нь талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 11.3 Гэрээний аль нэг заалт хүчин төгөлдөр бусад тооцогдсон нь бусад заалтын хүчинтэй байдалд нөлөөлөхгүй.
- 11.4 Гэрээний хавсралт, аливаа нэмэлт өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй нэг хэсэг байна.
- 11.5 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний 11.1-т заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Худалдагч _____ : _____ Гарын
үсэг _____

Хаяг _____ Утас: _____

Брокер: _____ Гарын үсэг _____ (тамга)

Худалдан авагч: _____ Гарын үсэг _____

Хаяг _____ Утас: _____

Брокер: _____ Гарын үсэг _____ (тамга)

Гэрээ баталгаажуулсан

Хөдөө аж ахуйн бирж ХХК-г төлөөлж:

Албан
тушаал: _____ Нэр: _____

Гарын үсэг _____ (тамга)

Хаяг _____ Утас: _____

“Биржээр бараа, түүхий эд худалдах, худалдан авах форвард гэрээ”-ний нэгдүгээр хавсралт

Форвард гэрээний нөхцөл

20... оны ... сарын ... өдөр

№

_____ хот

1. Форвард гэрээгээр худалдах, худалдан авах бараа, түүхий эдийн тодорхойлолт
 - 1.1. Бараа, түүхий эдийн нэр: _____
 - 1.2. Бараа, түүхий эдийн өнгө: _____
 - 1.3. Бараа, түүхий эдийн боловсруулалтын түвшин: _____
 - 1.4. Бараа, түүхий эдийн чанарын зэрэг: _____
 - 1.5. Бараа түүхий эдийн савлалт, хаягжилт: _____
2. Форвард гэрээгээр худалдах, худалдан авах бараа, түүхий эдийн хэмжээ: _____, (тоогоор) _____ (үсгээр)
3. Форвард гэрээгээр худалдах, худалдан авах бараа, түүхий эдийн үнэ: _____ (тоогоор), _____ (үсгээр)
4. Форвард гэрээгээр бараа, түүхий эд нийлүүлэх хугацаа: 20... оны ... сарын ... өдөр
5. Эхний төлбөр хийгдэх хугацаа: 20... оны ... сарын ... өдөр, үнийн дүн: _____, (тоогоор), _____ (үсгээр)
6. Форвард гэрээний бараа, түүхий эд хүлээлцэх газар: _____